



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2013 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/314

Улаанбаатар хот

Г
Соёл, урлагийн газрын дүрэм, бүтэц,
орон тооны хязгаарыг шинэчлэх
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2012 оны “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг батлах тухай” 190 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Соёл, урлагийн салбарын ажлын цар хүрээ, гүйцэтгэж байгаа ажил үүргийг харгалзан Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг “Соёл, урлагийн газар”-ын дүрмийг нэгдүгээр, бүтэц, орон тооны хязгаарыг хоёрдугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллахыг нийслэлийн Соёл, урлагийн газар /Б.Батцэнгэл/-т даалгасугай.
3. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2009 оны 608, 2011 оны 516 дугаар захирамжуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН
ОРЛОГЧ

Н.БАТАА

111020001226

Нийслэлийн Засаг даргын 2013 оны
03 зурагт.....сарынны өдрийн
1/314 зурагт.....захирамжийн 1 дүгээр
хавсралт

УХБ0011.8077243

СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газар /цаашид “газар” гэх/ Нийслэлийн хүн амд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл урлагийг хөгжүүлэх, соёлын өвийг хамгаалах, соёлын үнэт зүйлийг өвлүүлэн эзэмшүүлэх, тэдгээрийг сурталчлах, иргэдийн уран сайхны боловсрол, нийтийн соёлыг дээшлүүлэх, соёл урлагийн олон талт үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий нийслэлийн өмчийн төсөвт байгууллага мөн.

1.2 Газар нь үйл ажиллагаандaa Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Соёлын тухай болон холбогдох бусад хууль, тогтоомжууд, Төрөөс баримтлах соёлын бодлого, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Соёлын талаар Улаанбаатар хотоос баримтлах бодлого, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мериин хөтөлбөр, захирамж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3 Газар нь Нийслэлийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын удирдлага дор үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.

1.4 Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай, Нийслэлийн төрийн санд харилцах данстай байна.

Хоёр. Газрын удирдлага, зохион байгуулалт

2.1 Нийслэлийн Засаг дарга Газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоож, Монгол улсын Соёлын тухай хуулийн 15.2-т зааснаар соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцэн даргыг томилж чөлөөлнө.

2.2 Газрын дарга холбогдох хууль, тогтоомжийн дагуу хөдөлмөрийн дотоод журам, ажилтнуудын цалин урамшууллыг тогтоож, эрх хэмжээний хүрээнд тушаал гаргана.

2.3 Газрын дарга нь батлагдсан орон тооны хязгаарт багтаан Монгол улсын Төрийн албаны хуулийн дагуу хэлтсийн дарга, мэргэжилтэн, албан хаагчдыг томилж, чөлөөлнө.

2.4 Газрын даргын дэргэд байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж, зөвлөлгөө өгч байх орон тооны бус зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга батална.

Гурав. Газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл, эрх, үүрэг

3.1. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

3.1.1. Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлжээд үйл ажиллагаагаа чиглүүлж, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах;

3.1.2. Соёл урлагийн талаарх хууль, тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлангаж ажиллах;

3.1.3 Соёлын тухай, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай болон бусад хуулийг хэрэгжүүлэхдээ нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг соёл урлагийн байгууллагуудтай өмчийн хэлбэр үл харгалзан ажлын чиглэл өгч хамтран ажиллах;

3.1.4. Нийслэлийн иргэд, шилжин суурьшигчдыг соён гэгээрүүлэх, ахуйн, хэрэглээний, харилцааны болон суурин иргэншлийн соёлыг бүх хүрээнд төлөвшүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

3.1.5 Уламжлалт ёс заншил, зан үйл, нийтийн соёлыг хүүхэд, залуучуудад эзэмшүүлэх, төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах;

3.1.6. Соёл, урлагийн байгууллагын мэргэжлийн ажилтнуудыг тогтворт суурьшил, үр бүтээлтэй ажиллуулах, тэдний хөдөлмөрлөх нөхцлийг сайжруулах, мэргэжил боловсролыг дээшлүүлж мэргшүүлэх, ажлын арга барилыг боловсронгуй болгохтой холбогдсон мэргэжил, арга зүйн сургалт, семинар зохион байгуулах;

3.1.7 Нийслэлийн болон Улаанбаатарын бүсийн дэвсгэр нутаг дахь соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах, сурталчлах уламжлуулхатай холбогдсон харилцааг зохицуулан зохион байгуулах;

Дөрөв. Газрын эрх, үүрэг.

4.1. Газрын эрх

4.1.1. Соёл урлагийн ажил үйлчилгээтэй холбоотой асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд үүрэг, чиглэл өгөх, биелэлтийг хангуулах, мэдээ тайлан гаргуулах;

4.1.2. Соёл урлагийн үйл ажиллагаа явуулж байгаа харьяа болон нийслэлийн өмчит байгууллагын удирдах албан тушаалтыг ажилд томилох, ажлаас чөлөөлөхдээд Нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга санал өгч, тэдний ажлын талаар дүгнэлт гарган, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогчтой харилцана.

4.1.3. Соёл урлагийн чиглэлээр үйлчилгээ эрхлэхийг хүссэн байгууллага, аж ахуйн нэгж иргэдэд холбогдох журмын дагуу зөвшөөрөл олгон бүртгэлжүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, хуулийн хүрээнд ажиллахыг шаардах;

4.1.4. Нийслэлийн удирдлагатай зөвшилцөн ах дүү болон хамтын ажиллагаатай хотуудын Соёл урлагийн газруудтай хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулан ажиллах;

4.1.5. Харьяа болон нийслэлийн өмчит соёл урлагийн байгууллагуудын зохион байгуулалтын бүтцийг батлах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах асуудлыг зохих журмын дагуу Нийслэлийн Засаг даргад өргөн барьж шийдвэрлүүлэх;

4.1.6. Газрын батлагдсан төсвийг захиран зарцуулж, тайлагнах, харьяа байгууллагуудын үйл ажиллагааны жил, хэтийн зорилтыг баталж, төсвийн хуваарилалт хийж, зарцуулалт, гүйцэтгэл хяналт тавих.

4.1.7. Төрөөс нийгмийн салбарыг хувьчлахтай холбогдуулан Нийслэлийн Соёл урлагийн байгууллагуудын хувьчлалын бэлтгэл ажил, хувьчлалын үйл явц болон хувьчлагдсан байгууллагуудын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллах;

4.1.8. Хөдөлгөөнт соёлын төвийн үйл ажиллагааны орлого, зарлагыг байгууллагын төсөвт тусгаж батална.

4.1.9. Хувийн хэвшлийн соёл урлагийн байгууллага, чөлөөт уран бүтээлчдийн уран бүтээлийг дэмжих, тэдний үйл ажиллагаанд дүгнэлт өгөх, шаардлагатай арга хэмжээ авах;

4.1.10. Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийн зорилт, соёлын бодлогыг иргэдэд хүргэж ажиллах мэргэжлийн урлагийн байгууллагатай байх;

4.1.11. Соёл урлагийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсан байгууллага, иргэд, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан хүмүүсийг Төр засгийн болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шагналд тодорхойлох, газрын шагналаар шагнах.

4.2 Газрын үүрэг

4.2.1. Харьяа болон Нийслэлийн өмчтэй соёл урлагийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагааг нь уялдуулж, хяналт тавьж ажиллах;

4.2.2. Соёл урлагийн хувийн хэвшлийн байгууллагууд, чөлөөт уран бүтээлчдэд арга зүйн зөвлөлгөө өгч, иргэдэд үзүүлж байгаа соёлын үйлчилгээний хүртээмж, чанарт хяналт тавих;

4.2.3. Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хүний хөгжил, соёл урлагийг хөгжүүлэх талаар өргөн хүрээтэй хамтран ажиллах;

4.2.4. Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын орон тооны бүтцэд соёлын мэргэжилтэн ажиллуулах, тэдгээрийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, гурвалсан гэрээ байгуулж ажиллах.

4.2.5. Монголын үндэсний уламжлалт соёл урлаг, ёс заншлыг түгээн дэлгэрүүлэх, уламжлуулах ажилд соёл урлагийн ажилтнууд, авьяастай иргэдийг зохион байгуулж оролцуулах;

4.2.6. Нийтийг хамарсан урлаг, уран сайхны хөдөлгөөнийг бүх талаар дэмжин урлагийн наадам, уралдаан тэмцээн, соёл урлагийн баяр, өдруүдийг зохион байгуулах;

4.2.7. Нийслэл хотын түүх, соёлыг сэргээн сурталчлах, соёлын бизнес-аялал жуулчлалыг хөгжүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулах;

4.2.8. Түүх соёлын дурсгалт зүйлсийн археологи, архитектур, соёлын өв, урлагийн үнэт бүтээлийг хадгалах, хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, бүртгэлжүүлэх;

4.2.9. Иргэдийн чөлөөт цагийг зүй зохистой өнгөрүүлэх үйл ажиллагааны чиглэлээр соёлын үйл ажиллагааг зохион байгуулах;

4.2.10. Нийтийг хамарсан баяр ёслолын арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах .

4.2.11.Үйл ажиллагааны хүрээнд шаардлагатай асуудлаар санал боловсруулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаар шийдвэрлүүлэх;

4.2.12. Байгууллагын хэмжээнд сахилга, дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавих;

4.2.13 Соёл, урлагийн байгууллагуудын ажил, соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар санал асуулга явуулах, иргэдээс гаргасан санал хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн хүрээнд барагдуулах;

4.2.14. Соёл урлагийн салбарын үйл ажиллагааг Нийслэлийн биеийн тамир, спорт, аялал жуулчлалын үйл ажиллагаатай уялдуулах;

Тав. Хүлээх хариуцлага

5.1. Газрын дарга, ажилтан нар бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ болон энэхүү дүрмээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Зургаа. Бусад зүйл

6.1. Нийслэлийн Засаг даргын захирамжаар энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

6.2 Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг эрх бүхий байгууллагад тухай бүр мэдэгдэж бүртгүүлнэ.

Нийслэлийн Засаг даргын 2013 оны
05.дугаар сарын 29.ны өдрийн
1/3/1491/мж захирамжийн 2 дугаар
хавсралт

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН
БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Байгууллагын нэр	Хэлтэс,нэгжийн нэр	Орон тоо
1	Нийслэлийн Соёл, урлагийн газар	Захиргаа, удирдлагын хэлтэс	Нийт 20 Үүнээс: Дарга 1 Хэлтсийн дарга 3
		Урлаг, уран сайханы хэлтэс	
		Соёл хүний хөгжлийн хэлтэс	